

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/258-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2023 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
	Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. Аудитын тайлан	18-21
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	22-25
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	26-27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДС	Нийгмийн даатгалын сан
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА
С.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

2023.03.25 № СЭА-2023/258-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Олон жилийн турш хуримтлагдсан НДШ-ийн өр, авлагыг барагдуулахаар Цемент шохой ТӨХК-тай хамтран ажилласнаар 1995 оноос хойш хуримтлагдсан 5,740,460.9 мянган төгрөгийн, 2022 онд шинээр үүссэн 4,811,155.6 мянган төгрөгийн зэрэг нийт 10,551,616.5 мянган төгрөгийн НДШ-ийн авлагыг бүрэн барагдуулсан байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 98.6 хувийг нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардал эзэлж байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33,490,726.70	31,411,302.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,606,249.50	12,717,333.20
33	АВЛАГА	24,876,311.90	18,684,731.30
35	БАРАА МАТЕРИАЛ	8,165.30	9,237.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,351,046.00	1,373,095.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,351,046.00	1,373,095.00
39200	Биет хөрөнгө	1,336,608.80	1,358,657.80
39300	Биет бус хөрөнгө	14,437.20	14,437.20
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	34,841,772.70	32,784,397.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	403,403.30	713,794.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	403,403.30	713,794.50
41300	Өглөг	121,793.60	152,261.40
41400	Урьдчилж орсон орлого	281,609.70	561,533.20
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	34,438,369.40	32,070,602.60
51	Засгийн газрын хувь оролцоо	34,438,369.40	32,070,602.60
51100	Засгийн газрын оруулсан капитал	349,539.00	349,539.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	349,539.00	349,539.00
51200	Хуримтлагдсан үр дүн	33,953,306.60	31,585,539.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	135,523.80	135,523.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	34,841,772.70	32,784,397.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	225,000,896.70	143,427,550.90
11	ТАТВАРЫН ОРЛОГО	58,797,816.20	66,173,391.30
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	58,797,816.20	66,173,391.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	61,432.40	111,357.50
120	Нийтлэг татварын бус орлого	61,432.40	111,357.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	166,141,648.20	77,142,802.20
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	219,890,161.90	145,788,513.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	219,890,161.90	145,788,513.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	946,301.10	946,021.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	653,464.50	698,198.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,359.20	87,755.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,281.70	58,474.80
2104	Хангамж, бараа материалын зардал	30,242.20	18,776.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,926.80	1,919.40
2107	Томилолт, зочны зардал	3,598.50	6,883.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,090.60	16,523.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,337.40	57,491.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	218,943,860.80	144,842,492.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	5,110,734.90	-2,360,962.60
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	5,110,734.90	-2,360,962.60

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,243,110.00	0.00	29,243,110.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	84,524.60	0.00	84,524.60
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,327,634.50	0.00	29,327,634.50
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	5,110,734.90	0.00	5,110,734.90
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,438,369.40	0.00	34,438,369.40
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	34,438,369.40	0.00	34,438,369.40
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-6,804.20	0.00	-6,804.20
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	34,431,565.20	0.00	34,431,565.20
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	-2,360,962.60	0.00	-2,360,962.60
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	32,070,602.60	0.00	32,070,602.60

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	220,988,961.50	150,048,599.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	54,436,497.60	71,237,390.70
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	54,436,497.60	71,237,390.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	227,640.10	243,178.50
120	Нийтлэг татварын бус орлого	227,640.10	243,178.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	166,324,823.90	78,568,030.10
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	220,123,995.40	145,937,515.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	220,123,995.40	145,937,515.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	871,296.10	888,695.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	653,994.20	698,198.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,359.20	87,755.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,281.70	58,474.80
2104	Хангамж, бараа материалын зардал	20,361.00	20,061.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,706.20	1,919.40
2107	Томилолт, зочны зардал	3,598.50	6,883.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,183.70	13,845.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,811.60	1,559.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	219,252,699.20	145,048,819.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	864,966.20	4,111,083.70
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	864,966.20	4,111,083.70
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,741,283.30	8,606,249.50
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,606,249.50	12,717,333.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	122,681,795.40	121,946,719.76	735,075.64	99.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	122,681,795.40	121,946,719.76	735,075.64	99.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	911,852.30	888,695.70	23,156.60	97.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	704,459.30	698,198.11	6,261.19	99.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,282.60	87,755.04	8,527.56	91.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,352.60	58,474.80	877.80	98.52
2104	Хангамж, бараа материалын зардал	20,763.30	20,061.05	702.25	96.62
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,155.40	1,919.36	236.04	89.05
2107	Томилолт, зочны зардал	6,895.00	6,883.30	11.70	99.83
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,044.10	13,845.05	6,199.05	69.07
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,900.00	1,559.00	341.00	82.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121,769,943.10	121,058,024.06	711,919.04	99.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	121,769,943.10	121,058,024.06	711,919.04	99.42
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	122,681,795.40	77,097,797.67	45,583,997.73	62.84
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,463,128.70	17,463,128.70	0.00	100.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	105,218,666.70	59,535,655.56	45,683,011.14	56.58
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	99,013.40	-99,013.40	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	8,606,249.48	-8,606,249.48	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	12,717,333.20	-12,717,333.20	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	119	109	10.00	91.60
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	59	54	5.00	91.53
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	59	54	5.00	91.53

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс /цаашид Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс гэх/ нь "Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа хэрэгжүүлсэн бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах,
- Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх,
- Нийгмийн даатгалын сангийн орлогын бүрдүүлэлтийг хангах, уг сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт үйлчилгээний зардлыг цаг тухайд нь олгох,
- Нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагч иргэдэд шуурхай чирэгдэлгүй хүргэх,
- Үйлчилгээний чанар, хүртээмж, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах,
- Даатгалын үйлчилгээнд дэвшилтэд хэлбэр, маркетингийг нэвтрүүлэх,
- Менежментийн чадавхыг бэхжүүлэх, ажилтнуудыг чадваржуулах,
- Хууль тогтоомжийг сурталчлах ажлыг шинэ шатанд гаргах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин


Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд 2022 оны 11 дугаар сарын 11, 12 дугаар сарын 23-нд нэмэлт өөрчлөлт орсон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.



Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд НДЕГ-ын Дотоод аудит, мониторингийн газраас хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.



3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагад мөрдөж байгаа Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 онд боловсруулсан бөгөөд уг баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.


Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,057,375.6 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,606,249.5	12,717,333.2	4,111,083.7
Авлага	24,876,311.9	18,684,731.3	-6,191,580.6
Бараа материал	8,165.3	9,237.6	1,072.3
Үндсэн хөрөнгө	1,351,046.0	1,373,095.0	22,049.0
Нийт хөрөнгө	34,841,772.7	32,784,397.1	-2,057,375.6
Өр төлбөр	403,403.3	713,794.5	310,391.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	34,438,369.4	32,070,602.6	-2,367,766.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	34,841,772.7	32,784,397.1	-2,057,375.6

Эх сурвалж: Аймгийн НДХ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, засгийн газрын хувь оролцоо дансуудыг дор тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно. Үүнд:



3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 12,717,333.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,111,083.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	8,606,249.5	12,717,333.2	4,111,083.7
Төгрөг	8,606,249.5	12,717,333.2	4,111,083.7
Төрийн сангийн харилцах	16,972.1	1,568.2	-15,403.9
Арилжааны банк дахь харилцах	8,589,277.4	12,715,765.0	4,126,487.6
Дүн	8,606,249.5	12,717,333.2	4,111,083.7

Эх сурвалж: Аймгийн НДХ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд төрийн сангийн 5 харилцах дансанд байршиж буй 1,568.2 мянган төгрөг, арилжааны 4 банкин дахь 95 харилцах дансанд байршиж буй 12,715,765.0 мянган төгрөг зэрэг нийт 12,717,333.2 мянган төгрөг тайлагнагдсан байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 18,684,731.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,191,580.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
НДШ-ийн авлага	11,283,597.6	6,597,033.7	-4,686,563.9
Татаас, санхүүжилтийн авлага	12,859,201.5	11,361,077.0	-1,498,124.5
Байгууллагаас авах авлага	732,880.8	726,518.3	-6,362.5
Хувь хүмүүсээс авах авлага	631.9	102.3	-529.6
Дүн	24,876,311.8	18,684,731.3	-6,191,580.5

Эх сурвалж: Аймгийн НДХ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны үлдэгдэлд дараах авлагууд тайлагнагдсан байна. Үүнд:

- 501 байгууллагын 6,595,871.9 мянган төгрөгийн /1 жил хүртэл хугацаагаар төлөөгүй 2,039,872.9 мянган төгрөг, 4-өөс дээш жил төлөөгүй 4,555,999.0 мянган төгрөг/, хяналт шалгалтын акт, алдангийн 1,161.8 мянган төгрөгийн зэрэг нийт 6,597,033.7 мянган төгрөгийн НДШ-ийн авлага,
- Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн дагуу өмнөх онуудад үүссэн шимтгэл чөлөөлөлтийн авлага 12,225,401.5 мянган төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас олгох дэмжлэгийн авлага 633,800.0 мянган төгрөг зэрэг нийт

12,859,201.5 мянган төгрөгийн улсын төсвөөс авах татаас, санхүүжилтийн авлагаас тайлант онд шимтгэл чөлөөлөлтийн авлага 1,498,124.5 мянган төгрөгийг улсын төсвөөс авч 11,361,077.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй,

- 17 сум, 5 тосгонд байрлах нэгж хоорондын 513,566.4 мянган төгрөгийн, 101 байгууллага, аж ахуй нэгжтэй холбоотой 39,463.6 мянган төгрөгийн, 615 иргэнтэй холбоотой 173,590.5 мянган төгрөгийн зэрэг нийт 726,620.5 мянган төгрөгийн бусад авлага.



3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 9,237.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,072.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал	8,165.3	9,237.6	1,072.3
Бичиг хэргийн материал	536.5	642.1	105.6
Аж ахуйн материал	4,327.2	4,125.9	-201.3
Сэлбэг хэрэгсэл	859.8	859.8	0.0
Түлш, шатах тослох материал	0.0	1,380.0	1,380.0
Бусад хангамжийн материал	2,441.8	2,229.8	-212.0
Дүн	8,165.3	9,237.6	1,072.3

Эх сурвалж: Аймгийн НДХ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь тайлант онд 16,040.1 мянган төгрөгийн материал худалдан авсан, НДЕГ-аас 2,466.0 мянган төгрөгийн маягтыг хүлээн авсан болон 17,433.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас голлон шалтгаалжээ.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл / анхны өртгөөр / 1,654,132.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 33,519.5 мянган төгрөгөөр буурсан байна.


Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	1,673,214.9	1,639,695.4	-33,519.5
Барилга, байгууламж, орон сууц	1,387,219.7	1,387,219.7	0.0
Авто-тээврийн хэрэгсэл	12,540.0	12,540.0	0.0
Машин тоног төхөөрөмж (компьютер)	149,647.4	128,109.9	-21,537.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	123,807.8	111,825.8	-11,982.0
Биет бус хөрөнгө	14,437.2	14,437.2	0.0
Бусад биет бус хөрөнгө	14,437.2	14,437.2	0.0
Дүн	1,687,652.1	1,654,132.6	-33,519.5

Эх сурвалж: Аймгийн НДХ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 33,519.5 мянган төгрөгөөр буурсан нь НДЕГ-аас 70,216.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж шилжүүлэн авсан, ТӨБЗГ-ын даргын 2022 оны "Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай" 695 дугаар тогтоолын дагуу 72,677.4 мянган

төгрөгийн машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлыг акталж, данс бүртгэлээс хассан, “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” 646 дугаар тогтоолын дагуу ашиглалтын хугацаа дууссан 38,823.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмжийн үнийг шинэчлэн тогтоож, 7,764.6 мянган төгрөгөөр данс бүртгэлд тусгаснаас шалтгаалсан байна.



3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 713,794.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 310,391.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	121,793.6	152,261.3	30,467.7
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	281,609.7	561,533.2	279,923.5
Дүн	403,403.3	713,794.5	310,391.2

Эх сурвалж: Аймгийн НДХ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд дараах өглөгүүд тайлагнагдсан байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын сангаас иргэдэд олгох 10,079.2 мянган төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас иргэдэд олгох 24,274.2 мянган төгрөг, 17 сум 5 тосгонд байрлах нэгж хоорондын 54,697.7 мянган төгрөг, 155 байгууллага, аж ахуй нэгжтэй холбоотой 17,166.3 мянган төгрөг, 2198 иргэнтэй холбоотой 45,941.9 мянган төгрөг, банкны үйлчилгээний хураамжийн 102.0 мянган төгрөг зэрэг нийт 152,261.3 мянган төгрөгийн өглөг,
- НДШ урьдчилж төлсөн 468 байгууллагын 315,297.8 мянган төгрөгийн, сайн дурын даатгуулагчдаас НДШ урьдчилж төлсөн 1996 иргэний 61,803.8 мянган төгрөгийн, Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулиар нөхөн даатгалын шимтгэлийг дутуу төлснөөс шалтгаалан ажилласан жилээ тооцуулж чадаагүй 306 иргэнтэй холбоотой 6,206.6 мянган төгрөгийн, 0-3 насны хүүхдээ асарч буй 631 эхийн сайн дурын даатгалын шимтгэлд урьдчилан төлсөн 178,225.0 мянган төгрөгийн зэрэг нийт 561,533.2 мянган төгрөгийн урьдчилж орсон орлого байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 32,070,602.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,367,766.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	349,539.0	349,539.0	0.0
Хуримтлагдсан үр дүн	33,953,306.6	31,585,539.8	-2,367,766.8
Өмнөх үеийн үр дүн	28,842,571.7	33,946,502.4	5,103,930.7

Тайлант үеийн үр дүн	5,110,734.9	-2,360,962.6	-7,471,697.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	135,523.8	135,523.8	0.0
Дүн	34,438,369.4	32,070,602.6	-2,367,766.8

Эх сурвалж: Аймгийн НДХ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,367,766.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой байна.



3.4.7 Орлогын данс

НДШ-ийн орлого: Тус хэлтэс нь 2022 онд 49,409,222.0 мянган төгрөгийн НДШ-ийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 59,341,280.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 48,510,893.0 мянган төгрөг,
- Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого 5,111,140.6 мянган төгрөг,
- ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн орлого 4,694,700.9 мянган төгрөг,
- Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого 1,024,545.5 мянган төгрөг зэрэг.

Төсөвт байгууллагын өөрийн орлого: Нийгмийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу хугацаандаа шимтгэлээ төлөөгүй 80 аж ахуйн нэгж, байгууллагад 13,251.7 мянган төгрөгийн, 439 сайн дурын нийгмийн даатгалын даатгуулагчдад 11,146.0 мянган төгрөгийн алдангийг ногдуулж, **24,397.7** мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/ мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэврийн даатгалын шимтгэл	40,613,317.9	48,510,893.0	7,897,575.1	119.45
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,068,309.6	5,111,140.6	1,042,831.0	125.63
ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл	3,855,648.2	4,694,700.9	839,052.7	121.76
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	871,946.3	1,024,545.5	152,599.2	117.50
НДШ-ийн орлого	49,409,222.0	59,341,280.0	9,932,058.0	120.10
Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	24,397.7	24,397.7	-
Нийт дүн	49,409,222.0	59,365,677.7	9,956,455.7	120.15

Эх сурвалж: Аймгийн НДХ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 19.5 хувь, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого 25.6 хувь, ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн орлого 22.1 хувь ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого 17.5 хувиар тус тус давж биелсэн нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор НДШ-ийн орлогын төлөвлөгөөг багаар тооцож, баталснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь

тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийт 128,223,289.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 27,610,739.3 мянган төгрөгөөр бууруулж, 100,612,550.0 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 223,946.8 мянган төгрөгөөр,
- Урсгал шилжүүлгийг 27,213,223.7 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан нь голлон нөлөөлсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 22,069,245.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн тодотгол хийсэн байна. Үүнд:

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 10,979.1 мянган төгрөг,
- Урсгал шилжүүлгийг 22,058,150.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 122,681,795.4 мянган төгрөгийн төсөв баталж, НДС-аас 105,218,666.7 мянган төгрөг, улсын төсвөөс 17,463,128.7 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр НДС-аас 59,535,655.6 мянган төгрөгийн санхүүжилт, улсын төсвөөс 17,463,128.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 99,013.4 мянган төгрөг, нийт 77,097,797.7 мянган төгрөгийг авч, үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 121,946,719.8 мянган төгрөг буюу 92.4 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлыг 53,387.0 мянган төгрөгөөр, НДС-ийн зардлыг 681,688.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	861,276.4	846,424.9	14,851.5	98.28
2	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	5,670.0	5,079.5	590.5	89.59
3	Мэдээлэл, сурталчилгааны зардал	500.0	97.0	403.0	19.40
4	Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн хөлс	400.0	46.0	354.0	11.50
5	Харуул, хамгаалалтын зардал	3,000.0	2,500.0	500.0	83.33
6	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	29,037.7	24,611.9	4,425.8	84.76
7	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	61,063.9	29,151.3	31,912.6	47.74
8	Хуульд заасан үндэслэлээр алба	2,300.0	2,299.8	0.2	99.99
9	Бусад тусламж, дэмжлэг	8,513.1	8,163.7	349.4	95.90
10	НД-ын тэтгэвэр, тэтгэмж	121,710,034.3	121,028,345.6	681,688.7	99.44

	Дүн	122,681,795.4	121,946,719.7	735,075.7	99.40
--	-----	---------------	---------------	-----------	-------

Эх сурвалж: Аймгийн НДХ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 70 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал


Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 113,109,575.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,131,095.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 848,321.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор НДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн “Тодотгосон төсвийн хуваарь”, НДЕГ-ын даргын 2022 оны 01/1114 дүгээр “2022 оны тодотгосон төсвийн хуваарь хүргүүлэх тухай”, 01/1743 дугаар “Чиглэл хүргүүлэх тухай”, НДЕГ-ын Санхүү, бүртгэлийн газрын даргын 2022 оны 06/1234 дүгээр “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгүүдээр батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэн ажиллахыг чиглэл болгосон байна.

Үүний дагуу нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлыг бууруулан, гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус, байрны түрээс, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, хог хаягдлын зардал, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, багаж техник хэрэгсэл, урсгал засвар, томилт, банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж, хичээл үйлдвэрлэлийн зардалд хэмнэлт үүсгэхээр баталсны дагуу тус хэлтсээс дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:



- Урсгал шилжүүлгийг 32,262.2 мянган төгрөг, цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 14,788.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 4,167.2 мянган төгрөг зэрэг нийт **53,386.9** мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийг бий болгосон,
- Төсвийн хөрөнгөөр баярын арга хэмжээ зохион байгуулаагүй,
- Нийгмийн даатгалын байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэхтэй холбоотой уралдаан, тэмцээн, цайллага зохион байгуулаагүй, бэлэг дурсгалын зүйлс бэлтгээгүй, зөвхөн үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчлах, ажил олгогч, иргэд, даатгуулагчдад чиглэсэн ажлыг зохион байгуулж, ажил үйлчилгээгээ сайжруулах чиглэлээр "Нийгмийн даатгал 80 жил - 8 бүтээлч" аяныг амжилттай зохион байгуулан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээлбэл зохих 21 төрлийн 180 мэдээллийг бүрэн мэдээлсэн бөгөөд мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувьтай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,887.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 127,850.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага, 77,472.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөгдсөнөөс 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 10. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,887.7	1	1,887.7	100.0
Албан шаардлага	4	127,850.5	4	127,850.5	100.0
Зөвлөмж	3	77,472.6	2	60,097.4	66.6
Нийт дүн	8	207,210.8	7	189,835.6	87.5

Эх сурвалж: Аймгийн НДХ-ийн 2021, 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх аудитаар өгсөн холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан сумдад хуваарилж буй санхүүжилт, орлого төвлөрүүлэлт, тэтгэвэр, тэтгэмжийн тооцоолол, баримтын бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгах боломжгүй байлаа.

2. НДЕГ-ын даргын 2022 оны 01/1158 дугаар албан бичгээр Засгийн газрын 2021 оны 67 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах

комиссын дүрэм”-ийн 10.3¹-т заасан болзол шаардлагыг хангасан магадлагч эмчид мөнгөн тэтгэмж олгохоор заажээ.

Үүний дагуу Б.Батсүхэд **2,560.0** мянган төгрөгийн мөнгөн тэтгэмжийг 80224:Зөвлөл, хороо, комиссын гишүүд арга хэмжээний зардлын зүйлээс бус 80820:Бусад тусламж, дэмжлэг арга хэмжээний 213204:Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлаас тооцож, олгосон байна.



Цаашид хамааралтай арга хэмжээний зардлын зүйл дээр төсвийг баталж, тооцож олгож байх шаардлагатай байна.

3. 17 сум, 5 тосгонд байрлах нэгж хоорондын 513,566.4 мянган төгрөгийн, 101 байгууллага, аж ахуй нэгжтэй холбоотой 39,463.6 мянган төгрөгийн, 615 иргэнтэй холбоотой 173,590.5 мянган төгрөгийн зэрэг нийт 726,620,5 мянган төгрөгийн бусад авлага тайлагнагдсан байна.

Эдгээр авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах /эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх/ шаардлагатай байна.


4. Тус хэлтсийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлд ашиглагдаж байгаа санхүүгийн программ нь санхүүгийн тайлан мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийг боловсруулахад хүндрэлтэй, санхүүгийн тайлан тодруулга нь стандартын дагуу дансны төлөвлөгөө, хөтөлбөр, арга хэмжээний ангиллаар илэрхийлэгдээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага”-ыг хангахгүй байна. Өмнөх онуудад хийгдсэн аудитаар санхүүгийн программ хангамжид тавигдах стандарт шаардлагыг хангасан санхүүгийн программ ашиглах шаардлагатай байгааг удирдлагын анхааралд хандуулж байсан боловч өнөөг хүртэл шийдвэрлэгдээгүй байна.

¹ Төв болон орон нутгийн комиссын бүрэлдэхүүнд гурваас дээш жил тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан магадлагч эмч, төв комиссын дарга, нарийн бичгийн даргад 3 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас 3 жил тутамд олгоно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 406,155.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,081.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 15,454.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, 389,619.6 мянган төгрөгийн зөвлөмж өглөө.



5.1 Төлбөрийн акт

1. Сахилгын шийтгэлтэй албан хаагч Ц.Батцэрэнд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад **256.0** мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7 дахь “Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно.”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам”-ын 3 дугаар хавсралтын 2.7 дахь “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээлгэсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн урамшуулал олгохгүй” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй албан хаагчид олгосон үр дүнгийн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. 4 албан хаагч / жижүүр /-ийн цагийн тооцоог хянан баталгаажуулаагүйгээс илүү цагийн нэмэгдлийг **825.0** мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан **10,485,3** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Үүнд:

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас **2,500.0** мянган төгрөгийн камер,
- ЭМДС-аас санхүүжүүлсэн урамшууллаас ЭМД-ын шимтгэлийн орлого бүрдүүлэх чиг үүрэгт үл хамаарах албан хаагчдын улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд **7,985.3** мянган төгрөгийг тооцож олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.



Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай тохиолдолд төсвийн зохицуулалт хийлгэх албан шаардлага хүргүүлэв.

2. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд **4,969.5** мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм ...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

3. Жилийн эцэст бараа материал, үнэт цаасны үлдэгдлийн тооллого хийгээгүй, акт үйлдэж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1 “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллогыг бүрэн гүйцэт хийж байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэл дутуу нийт **8,798.6** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- **4,710.0** мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын жолоочийн тооцооны хуудасны үзүүлэлтүүдийг бүрэн хөтлөөгүй, 100 км-т зарцуулах жишиг 6 нормыг бодит байдалд үндэслэн тооцож, тогтоогоогүй,
- **4,088.6** мянган төгрөгийн албан томилолтын зардлыг тооцож олгохдоо албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцоогүй, ажиллуулахаар томилсон хугацаагаар байрны зардлыг тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.4-т "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно." Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр "Жишиг норм батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ын холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүчин төгөлдөр, баталгаажсан анхан шатны баримтад үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэн, бүртгэл тайланд тусгах, мөнгөн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өгөв.

Илрүүлэлт: Аудитын явцад Сүхбаатар сумын өндөр насны, тэжээгчээ алдсаны, тахир дутуугийн тэтгэвэр, Баянгол, Ерөө, Сайхан сумын ажилгүйдлийн тэтгэмж олголтыг түүвэрлэн шалгахад хувийн хэргийн бүрдлийн шаардлагыг хангаагүй баримт, материалыг үндэслэн **380,821.0** мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг тооцож олгосон байна. Үүнд:

1. Ажилгүйдлийн тэтгэмж:

Сайхан сум: Тэтгэмжийн хувийн хэрэгт олголт хийсэн тухай бүр тэмдэглэгээ хийлгүйгээр 253,018.0 мянган төгрөгийн тэтгэмжийг тооцож, олгосон,

Ерөө сум: Тэтгэмжийн хувийн хэрэгт ажлаас халсан тухай шийдвэрийн эх хувийг бус хуулбарыг хавсарган 46,446.1 мянган төгрөгийн тэтгэмжийг тооцож, олгосон,

2. Өндөр насны, тэжээгчээ алдсаны, тахир дутуугийн тэтгэвэр:

Сүхбаатар сум: Тэтгэврийн хувийн хэрэгт иргэний үнэмлэх, төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдийн төрсний гэрчилгээний мэдээллийг төрийн мэдээллийн "Хур" системээс авалгүйгээр хуулбарыг хавсарган 81,356.9 мянган төгрөгийн тэтгэврийг тооцож, олгосон байна.

Эдгээр нь НДҮЗ-ийн 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” 09 дүгээр тогтоолын 5.2-т “Ажлаас халагдсан ... 5.2.3: **Ажлаас халсан тухай шийдвэр, ...**”, 6.2-т “**Даатгуулагчид олгосон тэтгэмжийн хэмжээг сар бүр тэтгэмж олгох тухай мэдэгдэл, ажилгүйдлийн даатгалын сангийн харилцах дансны баримттай тулган шалган, баталгаажуулж, тэтгэмжийн олголтыг түүний хувийн хэрэгт тухай бүр тэмдэглэнэ**”, НДЕГ-ын даргын 2022 оны А/31 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”-ын Санамж 2-т “Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан даатгуулагч (иргэн)-ийн энэ журмын 2.1.2, 2.1.9-д заасан баримт бичгийг **төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээс, ... авна.**” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Тэтгэвэр, тэтгэмжийн хувийн хэрэгт шаардагдах баримт, бичгийг холбогдох журамд заасны дагуу бүрдүүлж, хавсаргах, тэтгэмж олгосон тухай бүр хувийн хэрэгт бичилт хийж байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Жилийн эцэст бараа материал, үнэт цаасны тооллогыг хийж, тооцоог бодож акт үйлдээгүй.	1	-	1	-		
Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан.	1	8,798.6		1	8,798.6	
Тэтгэвэр, тэтгэмжийн хувийн хэргийн бүрдлийн шаардлагыг хангаагүй баримт, материалыг үндэслэн тэтгэвэр, тэтгэмжийг тооцож олгосон.	1	380,821.0		1	380,821.0	
Дүн	7	406,155.4	2	1,081.0	2	389,619.6



Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				/мянган төгрөгөөр/
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Дүн							
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Дүн							
Нийт дүн							